

2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг Улсын Их Хурал 1992 онд баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 1997, 2007, 2020 онд баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын 2001 оны 61, 2006 оны 14 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулж ирсэн. Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан 126 гишүүнтэй Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу чуулганы хуралдааныг зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган байна.” гэж, 15.2 дахь хэсэгт “Чуулган нь нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ. ...” гэж заасан бөгөөд эдгээр хуралдааныг зохион байгуулахтай холбоотойгоор болон Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн үр нөлөөг сайжруулах чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдээс тодорхой саналууд гарч байна. Иргэд, олон нийт Улсын Их Хурлын гишүүний сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, Улсын Их Хурал нээлттэй, ил тод байх, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах шаардлагатайг илэрхийлдэг. Тиймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зохицуулалтад өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байна.

Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зохицуулалт нь Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцээгүй талаар дүгнэлт, тогтоол гаргасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн баталснаас хойш 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр болон 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулсан байна. Эдгээр өөрчлөлт нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр нарийвчлан зохицуулах шаардлагатай зарим асуудлыг хуульд нэмж тусгах, хууль зүйн дүгнэлт гаргах, төсвийн хүрээний мэдэгдэл болон тухайн жилийн төсвийн төсөл хэлэлцэх дэгийн зохицуулалтыг өөрчлөх, Улсын Их Хурлын Байнгын хороодын чиг үүргийн өөрчлөлттэй холбоотойгоор чуулганы хуралдааны дэгийн зарим зохицуулалтад өөрчлөлт оруулах зэрэг хүрээ хязгаарыг хамарсан байна.

Улсын Их Хурлын гишүүдийн тоо, Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаа төлөвлөлттэй, хэлэлцүүлгийн дэг ойлгомжтой, чуулганы үйл ажиллагаанд оролцож байгаа гишүүд, бусад албан тушаалтнуудын эрх, үүрэг тодорхой байх, хариуцлагатай байх чиглэлээр чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хурлын гишүүдээс гарч байгаа санал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэрэглэх явцад гарч байгаа нарийвчлан зохицуулах, хуулийн зүйл, хэсэг, заалтын хоорондын нийцлийг хангах шаардлагыг харгалзан үзэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн УИХ-06/125 дугаартай албан бичгээр бусад Байнгын хороодоос, мөн оны 3, 4 дүгээр сард Улсын Их Хурлын гишүүд, тэдгээрийн ажлын албаны ажилтнууд, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудаас санал авч ажилласан болно.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 7 зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төсөл нь Улсын Их Хуралд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, чуулганы хуралдааны явц, түүнд гишүүний оролцоо ил тод, нээлттэй байх, гишүүн чуулганы хуралдаанд хариуцлагатай оролцож, санал хураалтад биечлэн оролцох, гишүүний нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдал, ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны хуралдаанд оролцсон байдлын мэдээллийг тогтмол гаргаж, шаардлагатай бол хариуцлага хүлээлгэх талаар тусгана. Нөгөө талаар гишүүд чуулганы үйл ажиллагаанд илүү бүтээмжтэй, хэлэлцэж байгаа асуудалд хэлэлцүүлгийн үе шат бүрд тохирсон байдлаар, үр дүнтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэхээр хэлэлцүүлгийн үед асуулт асуух, хариулт авах хугацаа, хэлэлцүүлэгт мэтгэлцэх боломжийг нэмэгдүүлэх зэрэг хэд хэдэн чиглэлээр тодорхой өөрчлөлтүүд оруулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэгдүгээрт чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг сайжруулах, дэгийн зохицуулалтыг тодорхой болгох хүрээнд, хоёрдугаарт гишүүн болон чуулганы хуралдаанд мэдээлэл өгөх бусад албан тушаалтны сахилга хариуцлагыг сайжруулах замаар бүтээмжийг дээшлүүлэх хүрээнд дараах зарчмын өөрчлөлтүүдийг тусгахаар бэлтгэнэ. Үүнд:

Нэг. Чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг сайжруулах, дэгийн зохицуулалтыг тодорхой болгох хүрээнд:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл тогтоох бөгөөд нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилахаар заасан. Энэ зохицуулалтыг хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх Зөвлөлийн тогтоосон хугацаанд багтаан нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилж, урьдчилан нэр авахгүйгээр зохион байгуулахаар тусгана. Ингэснээр хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн явцад танхимд

байгаа гишүүд Зөвлөлийн тогтоосон хугацаанд багтаан урьдчилан авсан тооны хязгаарлалтгүйгээр, ирцэд бүртгүүлсэн дарааллаараа асуулт асууж, хариулт авна.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэгдсэн хуралдаан болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуух, түүнд хариулт авах хугацааг өөр өөрөөр зохицуулсан, түүнчлэн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлэг явуулахад асуулт асуух, хариулт өгөх хугацааг тодорхой зохицуулаагүй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд гишүүн нэгдсэн хуралдаан болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуух, түүнд хариулт өгөх, нэмэлт асуулт асууж, хариулт авах хугацааг жигд, ойлгомжтой байхаар зохицуулна. Зарим тусгайлсан зохицуулалттай буюу гишүүний асуулт асуух, хариулт авах хугацааг өөрөөр зааснаас бусад тохиолдолд гишүүн нэгдсэн хуралдаан болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуухдаа 4 минутаас илүүгүй асуух, хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл 2 хүртэл удаа 1 минутаар нэмэлт асуулт асуух, түүнд хариулах хугацаа мөн адил 4 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа 1 минутаас илүүгүй байна.

Хуралдаан даргалагч шаардлагатай бол гишүүний асуултад бүрэн хариулт өгөх, эсвэл гишүүний асуулттай холбогдуулан хэд хэдэн албан тушаалтнаас хариулт авах зорилгоор нэмэлт тайлбар өгөх хугацааг нэмж өгч болохоор тусгана. Хуралдаанд гишүүн асуулт асуух, түүнд хариулт өгөх хугацааг нэгтгэн тооцож, нийт хугацаагаар асуулт, хариултыг мэтгэлцэх буюу хэдэн ч удаа асуулт асуух, хариулт авах боломжтой байдлаар тусгана.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тодорхой хугацааны дотор хэлэлцэх асуудлын тов, дараалалд тусгах, хэлэлцүүлэгт оруулах зохицуулалтыг тусгана.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн явцад мэтгэлцээн зохион байгуулах зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ зохицуулалтаар нам, эвслийн бүлэг мэтгэлцээн зохион байгуулахаар санал, дүгнэлт гаргасан бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэхээр, түүнчлэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө нам, эвслийн бүлэг илтгэгч гишүүнийг томилж ирүүлэхээр заасан. Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргаж мэтгэлцээн зохион байгуулаагүй байна. Тиймээс хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн явцад гишүүн санал гаргаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол тухайн хэлэлцүүлгийн явцад нэг цагийн хугацаанд чөлөөт мэтгэлцээнийг шууд буюу нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргахгүйгээр, илтгэгч гишүүн томилохгүйгээр зохион байгуулах зохицуулалтыг тусгана.

5.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд хуулийн төслийг чуулганаар яаралтай хэлэлцүүлэх зохицуулалт тусгагдсан. Уг зохицуулалтаар чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх тохиолдолд нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж байгаа бөгөөд гишүүд материалтай танилцах хугацаа богино, түүнчлэн яаралтай хэлэлцэх болсон үндэслэлийн талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл авч чадахгүй байна. Иймд хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх үндэслэлийн талаарх Ерөнхий сайдын, эсхүл холбогдох Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонссоны дараа хэлэлцүүлэг явуулахгүйгээр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар

шийдвэрлэхээр нэмж тусгана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжсэн тохиолдолд хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй байхаар зохицуулж хуулийн зохицуулалт хоорондын уялдааг хангана.

6. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх болон олон улсын гэрээ соёрхон батлахаас бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар зохицуулсан байсан ч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр энэ зохицуулалтыг хүчингүй болгож, Байнгын хороо хүсэлт гаргасан тохиолдолд зөвлөмж гаргахаар зохицуулсан байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн зохицуулалтаар хууль зүйн зөвлөмжийг ямар хүрээг хамран гаргах нь тодорхойгүй байна. Тиймээс Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хууль, тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар хууль зүйн дүгнэлт гаргуулж болохоор тусгаж, уг хууль зүйн дүгнэлтийг ямар хүрээг хамруулан гаргах талаар тодорхой тусгана.

Түүнчлэн Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд Тамгын газраар зардлын тооцоо болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ хийлгэж болох зохицуулалтыг тусгана.

7. Хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх санал хураалт явуулах нь хууль санаачлагчийн хувьд цаашид өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт оруулах эсэхийг шийдвэрлэх чухал үе шат бөгөөд энэ шатанд хууль санаачлагч хуулийн төслийн талаар нэмэлт тайлбарыг өгөх боломжийг нэмэгдүүлэх нь чухал юм. Тиймээс Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлагч хуулийн төслийн талаарх гишүүдийн асуулт, үгтэй холбогдуулан хуулийн төслийн талаар тайлбар хэлж болохоор тусгана.

8. Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах санал хураалттай холбоотой зарим өөрчлөлтийг тусгах шаардлагатай. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхэд гишүүн горимын санал гаргасан бол хууль зүйн нэр томъёог жигдлэх зорилгоор хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар багцлан нэг санал хураалт явуулж болохоор тусгана. Түүнчлэн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх санал хураалт явуулахад эх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүйд тооцох зохицуулалтыг шинээр тусгана.

9. Улсын Их Хурлын гишүүн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт ажиллахдаа хариуцлагатай ажиллах шаардлага нэмэгдэж байна. Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг хэрхэн үр дүнтэй ажилласан, гишүүдийн идэвх оролцооноос Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн төслийн хэлэлцүүлгийн чанар хамаарч байна. Гэвч зарим талаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон гишүүдийн ирцээс хамаарч ажлын хэсэг хуралдахгүй хугацаа алдах тохиолдлууд гарч байна. Байнгын хорооны тогтоолоор байгуулж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн 10 хүртэл гишүүнтэй байхаар хуульд заасантай адил Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулах ажлын хэсгийн

бүрэлдэхүүний тооны дээд хэмжээг хуульд тусган заах шаардлагатай байна. Ингэснээр хэт олон гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдах, үүнээс үүдэлтэйгээр ажлын хэсгийн ирц бүрдэхгүй байх нөхцөл үүсэхгүй байх боломж бүрдэнэ. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн шатанд хэрэв хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулсан бол түүний ахлагч, эсхүл ажлын хэсгийн гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах, тухайн Байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч, эсхүл ажлын хэсгийн гишүүн асуултад хариулахаар тусгана.

10.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахад хууль санаачлагч хуулийн төслийн талаар тодруулга, тайлбар хийж болохоор заасан нь Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатанд төслийн талаар ерөнхий асуулт, хариулт явагдаж байгаа бөгөөд хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэгтэй давхацсан шинжтэй байна. Тиймээс Байнгын хороогоор хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад хуулийн төсөлтэй холбогдуулан гарсан зарчмын зөрүүтэй санал дээр хууль санаачлагч тайлбар хийж болох зохицуулалт тусгана.

11.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулж улсын төсвийн төслийг 5 үе шаттайгаар хэлэлцэхээр зохицуулсан. Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг хэлэлцэн баталсан хэлэлцүүлэг, бусад хүчин зүйлсийг харгалзан улсын төсвийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцэхээр тусгана.

12.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг зөвшилцөх, түүнчлэн зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан зөвшилцөх асуудлыг хэлэлцэх дэгийн зохицуулалтын нэгдсэн хуралдаанаар гарсан үр дүнг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэхтэй холбоотой зарим зохицуулалтыг тодорхой, ойлгомжтойгоор тусгана. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77, 80, 82 дугаар зүйлээр зохицуулсан хууль, тогтоолын төслийг батлахыг гишүүдийн олонх дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцох зохицуулалтыг тусгана.

13.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр тогтоолоор албан тушаалтныг Улсын Их Хуралтай зөвшилцөх, танилцах бол нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулж байгаа нь Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцээгүй гэж тогтоосон тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдэд өөрчлөлт оруулна.

14.Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулахтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим хэсэг, заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тухайлбал, сонсгол даргалагчийг холбогдох Байнгын болон дэд хорооны гишүүдээс сонгох, сонсгол даргалагч эзгүй бол холбогдох Байнгын, эсхүл дэд хорооны дарга сонсголыг даргалах, сонсгол явуулах журмын зохицуулалтыг ойлгомжтой болгох зэрэг асуудлыг хуулийн төсөлд тусгана.

15.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журамд шаардлагатай зарим өөрчлөлтийг оруулна.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүн болон чуулганы хуралдаанд мэдээлэл өгөх бусад албан тушаалтны сахилга хариуцлагыг сайжруулах замаар бүтээмжийг дээшлүүлэх хүрээнд:

1. Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн, Байнгын, дэд хорооны болон хянан шалгах түр хорооны хуралдаанд идэвхтэй оролцох, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол Ёс зүйн дэд хороо хэлэлцэн хариуцлага хүлээлгэдэг байх зохицуулалтыг тусгана. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зөвхөн өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаадад томилолтоор ажилласан бол хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзэхээр заасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг нийцүүлэн өөрчилж, ийнхүү хүндэтгэн үзэх шалтгаантай бол урьдчилан бичгээр мэдэгдэхээр тусгана.

Ёс зүйн дэд хороо гишүүний хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдлыг тодорхой хугацаанд нийтэд мэдээлэхээр тусгана.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан тухайн өдрийн ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцох одоогийн зохицуулалтыг хасна.

Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдаанд биечлэн оролцож санал өгөх зохицуулалтыг нэмж тусгана. Гишүүд санал хураалтад биечлэн оролцох, санал хураалтад хариуцлагатай оролцох, санал хураалтын тодорхой хувьд оролцоогүй тохиолдолд хариуцлага хүлээх зохицуулалтыг нэмж тусгана. Үүнтэй холбоотойгоор хуралдаан даргалагч санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минутын турш санал хураалтын хонх дуугаргах бөгөөд хонх дуугарсан бол гишүүд нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцох үүрэгтэй болохыг зааж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр санал хураалтад ирээгүй гишүүнийг санал хураалтын бүртгэлээс хасахаар тусгана. Санал хураалт явуулахын өмнө хуралдааны танхимд байгаа гишүүдийн тоог бүртгэж, тухайн бүртгэлээс буюу биечлэн оролцож байгаа гишүүдээс санал хураалтын дүнг гаргана.

Хуульд ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж явуулахаар тусгасан. Гар өргөж санал хураалт явуулах бол гишүүн тухайн асуудлыг дэмжиж байгаа, үгүйг тодорхой илэрхийлдэг байх шаардлагатай тул хэрэв гар өргөж санал хураалт явуулах бол гишүүн бүрийн нэрээр дуудаж саналыг авч, хуралдаан даргалагч дүнг зарлахаар тусгана.

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагад тусгагдсан хуралдаан даргалагч хуралдааны явцад хүлээлгэх хариуцлагаас хуралдаанд оролцох эрхийг хасах болон тухайн хуралдааныг орхин гарахыг үүрэг болгох хариуцлагыг хасаж, гишүүн чуулганы хуралдаанд оролцох, санал хураалтад оролцохтой холбоотойгоор хүлээлгэх хариуцлагыг нэмж тусгана.

Гишүүн хуульд заасан тодорхой тохиолдлоос бусад үед нэг сарын хугацааны нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй, эсхүл гишүүн ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн, эсхүл харьяалагдах Байнгын хорооны, эсхүл дэд хорооны хуралдаанд 5 ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол Ёс зүйн дэд хороо гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн зардлаас бусад

гишүүний төсвийн нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлага хүлээлгэхээр тусгана.

Гишүүн ажлын хэсгийн хуралдаанд хоёр ба түүнээс дээш удаа биечлэн оролцоогүй, түр хорооны хуралдаанд 3 удаа оролцоогүй бол бүрэлдэхүүнээс нь хасах зохицуулалтыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулалт илүү тодорхой, ойлгомжтой болж, хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн чанар, үр нөлөө нэмэгдэнэ.

Чуулганы шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал болон гишүүний сахилга, хариуцлага нэмэгдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар:

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгосон эрхийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг илүү ойлгомжтой, ил тод, бүтээмжтэй байлгах зорилготой болно.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.